

авлага яаралтай боловсруулан отряд, ангиудын сургалтын албанд хөргүүлснээр дадлага, сургуулилалт системтэй зохион байгуулагдах боддос болно.

2. Гишүүдийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах, дадлага сургуулилалтыг удирдах тусгай бэлтгэгдсэн сургагч-багшийг биеийн тамирын офицероос тусад нь орон тоо зохион байгуулалтаар шинээр бий болгож, түүнийн тогтоох бэлтгээний заавар боловсруулж хэрэгжүүлбэл үр дүнтэй байх боломжтой.

3. Бүлгийн гишүүдийг тодорхой тогтоосон хугацаанд атестатчлах журмаар тэдний идэвх санаачлагыг эерэгээр үндэх замаар сайшаал, шийтгэлийг зөв хослуулан хэрэглэх шаардлагатай.

4. Цэргийн алба хаагч, бие хүний мэдлэг чадвар, бие бялдар, дасгал сургуулилалтын стандартаар сэтгэл зүйн бэлтгэлийн шалгуур стандартыг тодорхойлох боломжтой.

*Д.Мөнхншагай - Хууль сахиулахын удирдлагын академийн
821 дүгээр дамжааны суралцагч, хошууч*

АГААРЫН ЗАМЫН ХИЛИЙН БООМТЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД УДИРДЛАГЫН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Хураангуй. Энэхүү илтгэлээр агаарын замын хилийн боомтын аюулгүй байдлыг нийгмийн төвшинд хэрхэн ханган хэрэгжүүлэж буй бийл явц, цаашид удирдлагын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар авч үзэхийг зорьлоо.

Түлхүүр үг: Аюулгүй байдал, агаарын замын хилийн боомт, хилийн боомтын аюулгүй байдал.

Монгол Улсын боддосний аюулгүй байдал, түүний боддос болсон оршин тогтнохуйн аюулгүй байдлын тухай ярихад маш олон эсрэгцсэн хандлага ажиглагдсан.

Зарим нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд гаднаас хэн ч заналхийлээгүй байна хэмээн нэгц тусалдг. Аюулгүй байдлынхаа асуудлыг бүрэн шийдчихсэн улс одоогоор энэ ертөнцд алга.

Харин одоохондоо Монгол Улс нь хүрш хоёр гэрээнтэйгээ тогтвортой ижил төвшинд харилцаатай учраас гаднаас халдах дайсангүй, тайван байна. Өөрөөр хэлбэл, Орос, Хятад хоёр улс бүрэн бүтэн, хүчирхэг, хоорондоо бас найрсаг харилцаатай байгаа учраас манай гадаад аюулгүй байдал нийгмийн баталгаатайд тооцогдоно.

Гэвч ийм байдал хэр удаан өргөлжлэх вэ гэдгийг бид зайлшгүй бодож, тооцож байх ёстой.

Олон улсын байдал, манай хөршүүд, хэрэглэн буй бүс нутгийн байдал сүүлийн жилүүдэд огт өөр болсон, хойшид өөр ч өөр болох нь тодорхой. Тиймээс л бид угтаж харж, алсыг баримжаалан оршин тогтнох, гадаад дотоод аюулгүй байдлаа бэхжүүлэхийн төлөө нөхдөрх ажиллах хэрэгтэй. Аюулгүй байдал гэдэг ерөнхий ойлголтыг янз бүрээр тайлбарлаж болно. Энэ ойлголт нь тодорхой тохиолдолд субъектын аюулгүй байдлын өвөрмөц онцлогийг илэрхийлэхийн зэрэгцээ, олон салбарт хэрэглэж болох нийтлэг утга агуулагдаж байдаг.

Аюулгүй байдлын талаарх энэхүү ойлголтыг В.Дайлын тайлбар тольд "аюулгүй бүрэн бүтэн байх, найдвартай, итгэлтэй байх" гэсэн бол, Я.Цэвэлийн тайлбар тольд: "аймар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй"¹ гэж тайлбарласан байдаг.

Бодит амьдрал дээр янз бүрийн аюулууд урьд нь байсан, одоо ч байгаа, цаашид ч байсаар байх нь тодорхой юм. Ийм учраас аюулгүй байдлын өнцгийн агуулгыг "аюулаас бодитойгоор хамгаалагдсан байдал, төлнийг найдвартай сөрөн зогсох чадвар" гэж тодорхойлж байна.

"Аюулгүй байдал" гэж тухайн улсад улс төр, эдийн засаг, нийгмийн тогтортой байдлыг хангах, хуулийг чанд сахин биелүүлэх бас эрх зүйн дэг журмыг хангуулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төр, эдийн засаг, нийгэм, цэрэг, экологи, мэдээллийн чанартай дотоод, гадаад аюул заналхийллээс хувь хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхолын хамгаалагдсан дархан байдал^{1 2},

"Хилийн аюулгүй байдал" гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ³,

"Нисэхийн аюулгүй байдал" гэж нисэхийн хөдөлгөөнийг хууль бус үйлдлээс хамгаалахтай холбогдсон цогцолбор арга хэмжээ⁴ гэж тус тус тодорхойлсон байна.

Иймд "Хилийн боомтын аюулгүй байдал" гэж юуг хэлэх тал дээр одоогоор эрх зүйн баримт бичгүүдэд тусгаагүй байна. Өөнийг нэгдсэн нэг ойлголттой болгох, хууль эрх зүйн баримт бичигт тусгаж баталгаажуулах шаардлагатай юм.

¹ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. — УБ., 1966. 60 дахь тал.

² М.Ганболд. Хилийн нэр томъёоны тайлбар толь. - УБ., 2010.33 дахь тал.

³ Монгол улсын хилийн тухай хууль. 5дугаар зүйл. 5.2 дахь хэсэг.

⁴ Иргэний нисэхийн тухай хууль. 3дугаар зүйл. 3.1.17 дахь хэсэг.

Хилийн боомтод аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь улсын хилийн аюулгүй байдлын салшгүй хэсэг бөгөөд хилийн хяналтын байгууллагын хяналт шалгалт явуулах бололцоог бүрдүүлэх, дэг журам сахиулах, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, онцгой нөхцөл үүссэн үед хэрэгжүүлэх цогц арга хэмжээнээс бүрдэнэ¹ хэмээн хуульд заасан.

Судлаач бидний үзэж байгаагаар "Хилийн боомтын аюулгүй байдал" гэж боомтын хяналт шалгалтын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцлийг хиймэл гийн хууль бус үйлдлээс хамгаалахтай холбогдсон цогц арга хэмжээ гэж тодорхойлж болох юм гэж үзэж байна.

Даяаршиж буй нөөцийн нийгэмд улс, үндэстэн хоорондын үзэл бодол, шашин шүтлэг, эрх мэдэл, газар нутгийн төлөх тэмцэл улам бүр зохион байгуулалтайгаар хэрэгээ тэлэх хандлагатай байгааг зайлшгүй харгалзан үзэх нь зүйн хэрэг юм.

Хүн төрөлхтөний үүсэл, хөгжлийн бүх үе шатанд хувь хүн, нийгэм, улс орон, хамтын нийгэмлэгийн амьдрал үйл ажиллагааны салшгүй дагуул нь аюул, занал байсаар ирсэн.

Нөөцийн байдлаар хилийн боомтын аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь "Улсын хил хамгаалалтыг зохион байгуулж удирдах тухай" Хилийн Цэргийн Командлагчын удирдамж, хилийн ангийн захирагчийн тушаал, салбарын даргын төлөвлөгөө зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд захирамжлагдан хэрэгжиж байна.

Монгол Улсын хилийн тухай хуульд: Хилийн боомтод нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гамшиг, онцгой нөхцөлийн үед улсын хил хамгаалах байгууллага холбогдох байгууллагатай хамтран тусгай дэглэм тогтоож, зохион байгуулалтын арга хэмжээ авна.

Хилийн боомтод жагсаал, цуглаан хийх, хяналтгүйг хаах болон бусад арга, хэлбэрээр хэвийн үйл ажиллагааг тасалдуулахыг хориглоно.

Улсын хил хамгаалах байгууллага шаардлагатай тохиолдолд хилийн боомтод мөрдөх журам, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон нэмэлт арга хэмжээ авч болно^{1 2} гэсний дагуу Хил хамгаалах байгууллагаас хилийн боомтын аюулгүй байдлыг хангах талаар хэрш орнуудаас судлан, харилцан ажиллагаатай байгууллагууд, орон нутгийн ард иргэдтэй харилцан, хуульд заасан дээрх нөхцөл үүссэн үед ажиллах үйл ажиллагаагаа чанаржуулахад анхаарч ажиллаж байна.

¹ Монгол улсын хилийн тухай хууль. 28дугаар зүйл. 28.10 дахь хэсэг

² Монгол улсын хилийн тухай хууль. 28дугаар зүйл. 28.11, 28.12, 28.13 дахь хэсэг

Даяарших Үйл явц хичтэй Үргэж байгаа энэ Үед дэлхийн улс орнууд улам бүр нээлттэй болж, улсын Үүд хаалга болсон хилийн шалган нэвтрүүлэх боомтыг хөгжүүлэх, нэвтрүүлэх хичин чадлыг сайжруулах, эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох талаар улс бүхэн хич чармайлтаа тавих шаардлагатай.

Ялангуяа Европын холбоо, зарим хөгжингүй улс орнууд хилийн боомтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан хилийн шалган нэвтрүүлэх боомт байгуулах, бие биедээ итгэл хүлээлгэх, технологийн дэвшил, арга хэрэгслийг ашиглах, хилийн менежментийг сайжруулах, хилийн хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоог зохицуулах талаар нэлээд үр дүнд хүрч байна. Тиймээс бид Үүрийн болон хүрш улсуудын хилийн боомтын аюулгүй байдлыг хангасан, цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд түлхэц болохоор, туршлага болгон нэвтрүүлэхээр, Үлгэр авч хэрэгжүүлэхээр зарим хилийн боомтын талаар судлан авч үзэх нь зүйтэй.

1. Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүрэг, хууль, тогтоомж, журмыг чанд мөрдөх.

2. Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэгдсэн Үйл ажиллагааг тасралтгүй, хараат бус зохион байгуулах.

3. Аюулгүй байдлыг хангах салбарын бүтэц, орон тоо, зэвсэглэл, тусгай хэрэгслийг хилийн боомтын болзошгүй эрсдэлд нийцүүлэх.

4. Боомтын болон хяналт шалгалтын бүсийг инженерийн байгууламж, техник, тоног төхөөрөмжүүр төхөөрөмжлөх.

5. Хилийн хяналтын байгууллагууд болон Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөлтүүдийг хийх, хамтарсан сургалт, дадлагыг тогтмолжуулах, харилцан ажиллагаа, уялдааг хангах.

6. Хилийн боомтод үүссэн онцгой нөхцлийн Үед хамтран ажиллах үүрэг бүхий байгууллагуудын хүлээх үүрэг, хариуцлага, хэрэгжүүлэх арга хэмжээг тогтоож, дадлага, чадвар эзэмшүүлэх.

7. Боомтын аюулгүй байдлын албанд ажиллагсдыг тусгай зориулалтын хувцас, аюулгүй байдлыг хангах тусгай хэрэгсэл, албаны нохойгоор хангах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх.

8. Хүрш орны талтай хилийн төлөөлөгчийн шугамаар тогтмол хамтран ажиллаж, мэдээ, мэдээллийг шуурхай солилцох зэрэг болно.

Хурдтай хувиран Үүрчлөгдөж байгаа Үнэмлэхүйн цаг Үед Үндэсний ашиг сонирхлоо тууштай хамгаалах, тусгаар тогтнол, хууль сахиулах бодлого хамтын ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох асуудал нь Хилийн боомтод Үйл ажиллагаа явуулж буй хилийн хяналтын

байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил иргэйн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгож хөгжлэх шаардлага тулгаран гарч ирж байна.

Энэ бөгөөд харахад хилийн боомтын аюулгүй байдлыг хангах чиглэл рэг бий байгууллагуудын ил ажиллагаанд ашиглагдаж байгаа хууль, эрх зүйн актыг судлан хэлэлцүүлэн нэгтгэн нэг ойлголтонд хэрхэх цаг болсон байна.

*У.Мөнхбат -Хууль сахиулахын удирдлагын академийн
821 дүгээр да.мжааны суралцагч дэд хурандаа*

ХИЛ ДАМНАСАН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ХИЛИЙН ОТЯДЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭРЭЭНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА

Хураангуй: Энэхүү илтгэлээр хил дамнасан гэж хэрэгтэй тэмцэх хилийн аюулгүй байдал хил хамгаалалтад тулгамдаж буй зарим асуудлыг хууль эрх зүйн хэрэгэнд судлаж, цаашид анхаарах асуудлыг хандаж тавихыг зорилоо.

Толхиргоо: Хил дамнасан гэмт хэрэг; хилийн отрядын ажллагаа, хууль бус цагаачлал

Орчин үед гэмт хэрэг нь нэг улсын нутаг дэвсгэрээс хальж, хоёр ба түүнээс дээш олон улсын нутаг дэвсгэр дамнасан илдэгдэх болсон. Гэмт хэргийн бүлэглэлд даяаршил, интернет зэрэг орчин үеийн илддэгдээс ашиг олохыг эрмэлзэж, гэмт илдлийн явцдаа хич хэрэглэх, мөнгө угаах, төрийн албан тушаалтнуудыг худалдан авах зэргээр улс орны санхүү, эдийн засагт ихээхэн хохирол учруулсаар байна. Хил орчмын нутаг дэвсгэрт дамын наймаа, хууль бус цагаачлал, аллага, хядлага зэрэг гэмт хэрэгтэй тэмцэхээр хязгаарлагдахгүй, улс орны нутаг дэвсгэрийн бусад хэсгүүдэд тэгээмэл гардаг аллага, дээрэм, хулгай гэх мэт хэргүүдтэй ч тэмцэх болдог. Гэвч зарим тохиолдолд эдгээр гэмт хэргүүд нь хил залгаа улсуудын ашиг сонирхлыг ханддэг юм. Тухайлбал зэргэлдээ улсын нутаг дэвсгэрт нэг улсын иргэд тээврийн хэрэгсэл, мал хулгайлах, дээрэм хийх болон бусад гэмт хэргүүдийг хил зорчин илддэг. Гэмт хэргтнүүд хэрэг илдсэнийхээ дараа төрийн улсын нутаг дэвсгэр рүү буцаж ордог, зарим тохиолдолд гэмт хэргтнүүд хариуцлага, ялаас мултрахын тулд зэргэлдээ улсын нутаг дэвсгэр рүү нууцаар нэвтрэн ордог байна. Энэ төрлийн гэмт хэргүүд нь тухайн нутаг дэвсгэрт нь гэмт хэрэг илдэгдсэн орны хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэгдэх ёстой. Мөн эдгээр гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор гэмт хэргтнүүдийг буцааж илч байх болон иргэн, эргэлийн хэргийн